



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.11.22 № ЗТ-1/149  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024. 11. 20 № ХХ/2294  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>30</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлд:

“26.ХЭЛЭЛЦСЭН нь: Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024. 11. 19 № 01/9543  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Таны 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1788 тоот албан бичгээр ирүүлсэн Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761003040



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.11.19 № 1/1844

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА**

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

151604447  
Аз. файл.2024

**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД**



**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Нам Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.” гэж тус тус заасан нь иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдэж улс төрийн нам байгуулах эрхийг баталгаажуулж өгсөн.

Улс төрийн намын тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд энэхүү хууль нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжсэн. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль тогтоомж болон тухайн намын дүрэм, намын хөтөлбөрт нийцүүлэн түүний үйл ажиллагаанд оролцох, намыг дэмжих, эс дэмжих эрхтэй.” гэж, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д “Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох;” гэж, 7.1.9-д “хууль тогтоомжид заасан журмын дагуу намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулж, сонгогчдод танилцуулах, сурталчлах;” гэж тус тус заасан. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намууд хуульд нийцүүлж дүрэм, журмаа шинэчлэн бүртгүүлэх зүй ёсны шаардлага үүссэн.

Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ.”, 17 дугаар зүйлийн 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;”, мөн зүйлийн 17.4 дэх хэсэгт “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна.” гэж тус тус хуульчилсан боловч нэгэнт үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа улс төрийн намын хувьд дүрэм, журмаа Улсын дээд шүүхэд бүртгүүлчихсэн тул зөвхөн дүрэм, журмаа хуульд нийцүүлэн шинэчлэн батлаад бүртгүүлэх асуудал үүссэн. Энэхүү асуудлыг Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар шийдвэрлэхээр болсон. Тухайлбал, Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “нам

өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.” хэмээн заажээ.

## **1.2. Практик шаардлага**

Улс төрийн намын тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

Энэхүү хуулиар намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлэхээр, намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг зохицуулалтыг оруулсан бөгөөд дүрэм, журмаа Улсын дээд шүүхэд бүртгүүлэн хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн намын хувьд Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбоотойгоор уг хуульд намын дүрэм, журмаа нийцүүлэх зайлшгүй шаардлага үүссэн.

Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудад Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт улс төрийн нам шинээр байгуулсан бол дүрмээ 60 хоногийн дотор бүртгүүлэх зэрэг шилжилтийн зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөж журмын тухай хуулийг баталсан. Энэ хуулийн 2 дугаар зүйлд “нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.” хэмээн заажээ.

Гэтэл хууль хэрэгжиж эхэлсэн он буюу 2024 оны 06 дугаар сард Улсын Их Хурлын ээлжит сонгууль, 10 дугаар сард орон нутгийн сонгуулийн жил таарсан нь улс төрийн намуудад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хэд хэдэн хориглосон заалтыг зөрчих магадлал үүссэн тул улс төрийн намууд дүрэм, журмаа өөрчлөх талаар хэлэлцүүлэг, намын бүх шатны гишүүдийн шат шатны хурлаараа оруулан хэлэлцэж чадахгүйд хүрсэн.

Түүнчлэн улс төрийн намууд 2024 оны 01 дүгээр сараас эхлэн Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулах, нэр дэвшигчээ тодруулах, сонгуулийн сурталчилгаа хийх, сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хурал, шинэ Засгийн газрыг эмхлэн байгуулах, шинэ Засгийн газрын гурван талт гэрээг боловсруулж байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэсэн.

Мөн 2024 оны 10 дугаар сард болсон орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаа явагдаж дуустал улс төрийн намуудад дүрэм, журмаа шинэ хуульд нийцүүлэх боломж, хугацаа байсангүй.

Улс төрийн нам дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа намын бүх гишүүд, аймаг, нийслэлийн анхан шатны намууд хуралдах, сумын, аймгийн намын хорооны гишүүдээс санал авах, эцэст нь намууд их хурлаа хийж тэндээс батлагдсан дүрмийг Улсын дээд шүүхэд бүртгүүлэх юм. Энэ ажлуудыг зохион байгуулахад багагүй хугацаа шаардлагатай байна.

Иймд Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан намууд дүрмээ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэн батлуулж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан хугацааг хойшлуулж, улс төрийн намуудад бодит хугацааг тогтоож өгөх хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 2 зүйлтэй. Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 2027 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.” гэж хугацаа хойшлуулах өөрчлөлт болон хуулийн төслийг дагаж мөрдөж эхлэх хугацааг тусгасан хуулийн төслийг боловсруулах болно.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлаас батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжих боломжтой болохын зэрэгцээ Улс төрийн намууд дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа намын бүх гишүүд, аймаг, нийслэлийн анхан шатны намын нэгж хуралдах, сумын, аймгийн намын хорооны гишүүдээс санал авах, эцэст нь нам их хурлаа хийж тэндээс батлагдсан дүрмийг Улсын дээд шүүхэд бүртгүүлэх боломж бүрдэх юм.

Улсын дээд шүүхэд нийт 37 улс төрийн нам бүртгэлтэй бөгөөд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд 22 нам эвсэл оролцсон. Эдгээр нам эвслүүдэд дүрэм, журмаа хуульд нийцүүлэн шинэчилж Улсын дээд шүүхэд бүртгүүлэх боломж бүрдэнэ.

### **Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар**

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

---oOo---



## ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Нам Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.” гэж заасан нь иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдэж улс төрийн нам байгуулах эрхийг баталгаажуулж өгсөн.

Улс төрийн намын тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд энэхүү хууль нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжсэн. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль тогтоомж болон тухайн намын дүрэм, намын хөтөлбөрт нийцүүлэн түүний үйл ажиллагаанд оролцох, намыг дэмжих, эс дэмжих эрхтэй.” гэж, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д “Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох;” гэж, 7.1.9-д “хууль тогтоомжид заасан журмын дагуу намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулж, сонгогчдод танилцуулах, сурталчлах;” гэж тус тус заасан. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намууд хуульд нийцүүлж дүрэм, журмаа шинэчлэн бүртгүүлэх зүй ёсны шаардлага үүссэн.

Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ.” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна.” гэж тус тус хуульчилсан боловч нэгэнт үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа улс төрийн намын хувьд дүрэм, журмаа Улсын дээд шүүхэд бүртгүүлчихсэн тул зөвхөн дүрэм, журмаа хуульд нийцүүлэн шинэчлэн батлаад бүртгүүлэх асуудал үүссэн. Энэхүү асуудлыг Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар шийдвэрлэхээр болсон. Тухайлбал, Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.” гэж заажээ.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд Улсын дээд шүүхэд нийт 37 улс төрийн нам бүртгэлтэй бөгөөд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд 22 нам

эвсэл оролцсон. Эдгээр нам эвслүүдэд дүрэм, журмаа хуульд нийцүүлэн шинэчлэн Улсын дээд шүүхэд бүртгүүлэх зайлшгүй шаардлагатай.

Гэтэл хууль хэрэгжиж эхэлсэн он буюу 2024 оны 06 дугаар сард Улсын Их Хурлын ээлжит сонгууль, 10 дугаар сард орон нутгийн сонгуулийн жил таарсан нь улс төрийн намуудад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хэд хэдэн хориглосон заалтыг зөрчих магадлал үүссэн тул улс төрийн намууд дүрэм, журмаа өөрчлөх талаар хэлэлцүүлэг, намын бүх шатны гишүүдийн шат шатны хурлуудаа хийж чадахгүйд хүрсэн.

Мөн Улс төрийн намууд 2024 оны 01 дүгээр сараас эхлэн Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулах, нэр дэвшигчээ тодруулах, сонгуулийн сурталчилгаа хийх, сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хурал, сонгуулийн үр дүнгээр шинэ Засгийн газрыг эмхлэн байгуулах, үүний дараа орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаа явагдаж дуустал аль нэг улс төрийн намуудад дүрэм, журмаа шинэ хуульд нийцүүлэх боломж, хугацаа байсангүй.

Улс төрийн нам дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа намын бүх гишүүд, аймаг, нийслэлийн анхан шатны намууд хуралдах, сумын, аймгийн намын хорооны гишүүдээс санал авах, эцэст нь намууд их хурлаа хийж тэндээс батлагдсан дүрмийг Улсын дээд шүүхэд бүтгүүлэх юм. Энэ ажлуудыг зохион байгуулахад багагүй хугацаа шаардлагатай байна.

Иймд Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан намууд дүрмээ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэн батлуулж Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг хойшлуулж улс төрийн намуудад бодит хугацааг тогтоож өгөх хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлаас батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжих боломжтой болохын зэрэгцээ Улс төрийн намууд дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа намын бүх гишүүд, аймаг, нийслэлийн анхан шатны намын нэгж хуралдах, сумын, аймгийн намын хорооны гишүүдээс санал авах, эцэст нь нам их хурлаа хийж тэндээс батлагдсан дүрмийг Улсын дээд шүүхэд бүтгүүлэх боломж бүрдэх юм.

---oOo---

## **УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

Хуулийн төсөл нь 2 зүйлтэй. Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 2027 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.” хэмээн хугацаа хойшлуулах өөрчлөлт, болон хуулийн үйлчлэх хугацааг зааж өгсөн.

Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д намууд дүрэм, журмаа нийцүүлэн шинэчлэн батлах шаардлага үүссэн. Энэхүү хуулиар Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлэхээр, намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг зохицуулалтыг оруулсан байгаа бөгөөд үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа улс төрийн намын хувьд дүрэм, журмаа Улсын дээд шүүхэд бүртгүүлчихсэн хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн хувьд намын дүрэм, журмаа шинэчилсэн найруулгын хуульд нийцүүлэх зайлшгүй шаардлага үүссэн.

Гэтэл хууль хэрэгжиж эхэлсэн он буюу 2024 оны 06 дугаар сард Улсын Их Хурлын ээлжит сонгууль, 10 дугаар сард орон нутгийн сонгуулийн жил таарсан нь улс төрийн намуудад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хэд хэдэн хориглосон заалтыг зөрчих магадлал үүссэн тул улс төрийн намууд дүрэм, журмаа өөрчлөх талаар хэлэлцүүлэг, намын бүх шатны гишүүдийн шат шатны хурлуудаа хийж чадахгүйд хүрсэн.

Мөн Улс төрийн намууд 2024 оны 01 дүгээр сараас эхлэн Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулах, нэр дэвшигчээ тодруулах, сонгуулийн сурталчилгаа хийх, сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хурал, сонгуулийн үр дүнгээр шинэ Засгийн газрыг эмхлэн байгуулах, үүний дараа орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаа явагдаж дуустал аль нэг улс төрийн намуудад дүрэм, журмаа шинэ хуульд нийцүүлэх боломж, хугацаа байсангүй.

Улс төрийн нам дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа намын бүх гишүүд, аймаг, нийслэлийн анхан шатны намууд хуралдах, сумын, аймгийн намын хорооны гишүүдээс санал авах, эцэст нь намууд их хурлаа хийж тэндээс батлагдсан дүрмийг Улсын дээд шүүхэд бүтгүүлэх юм. Энэ ажлуудыг зохион байгуулахад багагүй хугацаа шаардлагатай байна.

Иймд Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд

заасан намууд дүрмээ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэн батлуулж Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг хойшлуулж улс төрийн намуудад бодит хугацааг тогтоож өгөх хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны сайтад байршуулж, олон нийтийн хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд хуулийн төсөлд холбогдох саналд ирээгүй байна.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**"2 дугаар зүйл.** Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 2027 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ  
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д намууд дүрэм, журмаа нийцүүлэн шинэчлэн батлах шаардлага үүссэн. Энэхүү хуулиар Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлэхээр, намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг зохицуулалтыг оруулсан бөгөөд дүрэм, журмаа Улсын дээд шүүхэд бүртгүүлчихсэн хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн хувьд намын дүрэм, журмаа Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх зайлшгүй шаардлага үүссэн.

Гэтэл хууль хэрэгжиж эхэлсэн он буюу 2024 оны 06 дугаар сард Улсын Их Хурлын ээлжит сонгууль, 10 дугаар сард орон нутгийн сонгуулийн жил таарсан нь улс төрийн намуудад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны хэд хэдэн хориглосон заалтыг зөрчих магадлал үүссэн тул улс төрийн намууд дүрэм, журмаа өөрчлөх талаар хэлэлцүүлэг, намын бүх шатны гишүүдийн шат шатны хурлуудаа хийж чадахгүйд хүрсэн.

Мөн Улс төрийн намууд 2024 оны 01 дүгээр сараас эхлэн Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулах, нэр дэвшигчээ тодруулах, сонгуулийн сурталчилгаа хийх, сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хурал, сонгуулийн үр дүнгээр шинэ Засгийн газрыг эмхлэн байгуулах, үүний дараа орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаа явагдаж дуустал аль нэг улс төрийн намуудад дүрэм, журмаа шинэ хуульд нийцүүлэх боломж, хугацаа байсангүй.

Улс төрийн нам дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа намын бүх гишүүд, аймаг, нийслэлийн анхан шатны намууд хуралдах, сумын, аймгийн намын хорооны гишүүдээс санал авах, эцэст нь намууд их хурлаа хийж тэндээс батлагдсан дүрмийг Улсын дээд шүүхэд бүтгүүлэх юм. Энэ ажлуудыг зохион байгуулахад багагүй хугацаа шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд Улсын Дээд шүүхэд нийт 37 улс төрийн нам бүртгэлтэй бөгөөд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд 22 нам эвсэл оролцсон. Эдгээр нам эвслүүдэд дүрэм, журмаа хуульд нийцүүлэн шинэчлэн Улсын Дээд шүүхэд бүртгүүлэхэд боломж бүрдэнэ.

Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан намууд дүрмээ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэн батлуулж Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг хойшлуулж улс төрийн намуудад бодит хугацааг тогтоож өгөх хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

## **УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

### **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна.

### **ХОЁР. АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН**

Улс төрийн намын тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд энэхүү хууль нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжсэн. Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ.” гэж заасан.

Улсын дээд шүүхэд бүртгүүлчихсэн хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн намуудын хувьд намын дүрэм, журмаа Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэх зайлшгүй шаардлага үүссэн. Мөн дүрэм нь Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй намуудын хувьд хуульд заасан уг хугацааг дагаж мөрдөх боломжгүй тул уг хуулийг хэрэгжүүлэхийн тулд Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны баталсан Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/тай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.” хэмээн заажээ.

Гэтэл хууль хэрэгжиж эхэлсэн он буюу 2024 оны 06 дугаар сард Улсын Их Хурлын ээлжит сонгууль, 10 дугаар сард орон нутгийн сонгуулийн жил таарсан нь улс төрийн намуудад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны хэд хэдэн хориглосон заалтыг зөрчих магадлал үүссэн тул улс төрийн намууд дүрэм, журмаа өөрчлөх талаар хэлэлцүүлэг, намын бүх шатны гишүүдийн шат шатны хурлуудаа хийж чадахгүйд хүрсэн.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд Улсын Дээд шүүхэд нийт 37 улс төрийн нам бүртгэлтэй бөгөөд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд 22 нам эвсэл оролцсон байна.

Иймд энэхүү хууль нь цаг үеэ олсон, дээрх олон харилцааг зохицуулахад чиглэсэн чухал шаардлагатай хуулийн төсөл болсон байна.

**ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ  
ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Улс төрийн нам дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа намын бүх гишүүд, аймаг, нийслэлийн анхан шатны намууд хуралдах, сумын, аймгийн намын хорооны гишүүдээс санал авах, эцэст нь намууд их хурлаа хийж тэндээс батлагдсан дүрмийг Улсын дээд шүүхэд бүтгүүлэх юм. Энэ ажлуудыг зохион байгуулахад багагүй хугацаа шаардлагатай байна.

Иймд Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан намууд дүрмээ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэн батлуулж Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг хойшлуулж улс төрийн намуудад бодит хугацааг тогтоож өгөх хуулийн төслийг санаачлан боловсруулсан байна.

**ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН  
ЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

	<b>Хувилбар</b>	<b>Зорилгод хүрэх байдал</b>	<b>Зардал, үр өгөөжийн харьцаа</b>
1	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой	Илүү зардал гарахгүй

**ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН  
БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

**ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

<b>Үзүүлэх үр нөлөө:</b>	<b>Холбогдох асуултууд</b>	<b>Хариулт</b>	<b>Тайлбар</b>
1.Хүний эрхийн суурь зарчмуудад	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.



<b>нийцэж буй эсэх</b>	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	<b>Тийм</b>		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>1.2. Оролцоог хангах</b>				
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	<b>Тийм</b>		Шударга ёсны зарчимд нийцсэн
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>		Шударга ёсны зарчимд нийцнэ
<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	<b>Тийм</b>		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	<b>Тийм</b>		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		<b>Үгүй</b>	энэ асуудалтай холбогдолгүй
